

**МОНГОЛ УЛСЫН ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГЫН ХӨГЖИЛД БНМАУ-ЫН
ПРОКУРОР СОДНОМБАЛЖИРЫН БУДРАГЧААГИЙН
ГҮЙЦЭТГЭСЭН ТҮҮХЭН ҮҮРЭГ**

HISTORICAL ROLE OF MR. BUDRAGCHAA SODNOMBALJIR, FORMER PROSECUTOR
GENERAL OF MONGOLIA IN THE DEVELOPMENT OF THE PROSECUTION SERVICE OF
MONGOLIA

Б.Мөнхдорж

*Хууль зүйн ухааны доктор, дэд профессор
(Улсын ерөнхий прокурорын газрын
дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэн)*

Ц.Мөнхбат

*Хууль зүйн ухааны доктор, дэд профессор
(Улсын ерөнхий прокурорын газрын
дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэн)*

Товч агуулга: Энэхүү өгүүллээр БНМАУ-ын прокурор Содномбалжирын Будрагчаагийн Монгол Улсын Прокурорын байгууллагын хөгжилд гүйцэтгэсэн түүхэн үүргийг хуульчийн намтар судлалын талаас авч үзсэн. Түүний хууль зүйн салбарт оруулсан гавьяа зүтгэлийг хуульч, судлаач, оюутан суралцагчдад хүргэх, нийтэд түгээх зорилгоор өгүүллийг бичсэн.

Тэрээр БНМАУ-ын прокуророор томилогдон ажиллах хугацаандаа прокурорын байгууллагыг бэхжүүлэх, нийгэмд прокурорын гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх, улс орны амьдралд бий болсон өөрчлөлт, шинэчлэлийн урьдач нөхцөл бүрэлдсэн цаг хугацаанд хууль ёсыг сахиулахад үнэтэй хувь нэмэр оруулсан эрхэм хуульч гэдгийг бодит баримт, эх сурвалжид үндэслэн эрдэм шинжилгээ, судалгааны талаас судалсан юм.

Abstract: This article explores the historical role of Mr. Budragchaa Sodnombaljir, former Prosecutor General in the development of the Prosecution Service of Mongolia through the lens of legal biography studies. The research aims to highlight and disseminate his contributions to the legal field among lawyers, researchers, and students.

As the Prosecutor General of the Mongolian People's Republic (MPR), Mr. Budragchaa Sodnombaljir played a key role in strengthening the Prosecution Service by expanding its functions in society and ensuring the rule of law during the transformative period of social change and reform. The study offers an academic and analytical perspective on his legacy based on real facts and reliable sources.

Түлхүүр үг: Хуульч, хуульчийн намтар судлал, прокурор, прокурорын хяналт, социалист хууль ёс сэтгүүл, шинжлэх ухаанч, бүтээлч хандлага, хүний эрх, шударга ёс.

Keywords: Lawyer, legal biography studies, prosecutor, prosecutorial supervision, Socialist Law Journal, scientific and innovative approach, human rights, justice.

Оршил

Улсын прокурор, төрийн хууль цаазын жинхэнэ зөвлөх,¹ хошууч генерал, төр, нийгмийн нэрт зүтгэлтэн Содномбалжирын Будрагчаа 1954-1956 онд Завхан аймгийн прокурорын газарт

¹ 1983 онд Төрийн хууль цаазын жинхэнэ зөвлөх цол хүртсэн.

хэсгийн прокурор², 1958-1961 онд Улсын прокурорын туслах прокурор, 1965-1968 онд Улаанбаатар хотын прокурор³, 1968-1969, 1979-1982 онд Улсын прокурорын нэгдүгээр орлогч, 1982-1988 онд БНМАУ-ын прокуророор томилогдож, төрийн өндөр албан тушаал, хариуцлагатай албыг нэр төртэй хашсан эрхэм юм. С.Бүдрагчаа прокурор Улсын прокурорын нэгдүгээр орлогчоор ажиллаж байхдаа Гэмт хэргийн шалтгаан, нөхцөл судлах хүрээлэнгийн захирал, “Социалист хууль ёс” сэтгүүлийн эрхлэгчээр хавсран ажиллаж байсан.⁴

Энэхүү өгүүллийг бичихдээ хэрэглэсэн судалгааны арга зүй нь түүхэн эх сурвалж, баримтуудыг түүвэрлэн судлах, дүн шинжилгээ хийх аргаар бичсэн гэдгийг дурдъя.

Нэгдүгээрт. Прокурорын байгууллагын хяналтын тогтолцоо, арга барилд дүгнэлт хийж, цаашид боловсронгуй болгоход анхаарч ажиллаж байсан.

Тэрбээр 1987 онд БНМАУ-ын Ардын Их Хурлын чуулганд илтгэл тавьсан. Үүнд: “Прокурорын байгууллагын үйл ажиллагаанд оршиж буй алдаа дутагдлыг даруй халж өөрчлөх болно. Прокурор болон хуулийн бусад байгууллага мэргэжлийнхээ ажлыг амьдралын шаардлагын дагуу шинэ маягаар зохион байгуулж явуулах, тэгэхдээ дор дурдсан дутагдлыг анхаарах шаардлагатай гэж үзэж байна. Тухайлбал, гэмт явдлын тухай иргэдээс гаргасан гомдол, мэдээлэлд хөшүүн хойрго хандах, шалгаж шийдвэрлэхээс үндэсгүй татгалзах, хэргийг хууль бусаар хэрэгсэхгүй болгох, гарсан хэргийн эзнийг тогтоож чадахгүй алгуурлах явдал хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллага тухайлбал, цагдан сэргийлэх, прокурорын үйл ажиллагаанд байна. Эрүүгийн хэргийг үндэслэлгүйгээр үүсгэж явуулах, хүнийг хилсдүүлэх, хохироох явдал ч гарсныг ч нуухын хэрэггүй юм.

Прокурорын байгууллага иргэдийн санал, өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шуурхай, үндэслэлтэй шийдвэрлэхгүй байгаа дутагдал оршоор байна. Энэ бол иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах чухал үүрэгтэй манай прокурорын байгууллагад үндсээрээ харш гэдгийг санаж, уг ажлыг шаардлагын түвшинд хүргэхийг нэг гол зорилтоо болгон хэрэгжүүлбэл зохино.

Прокурорын байгууллагын ажлын арга барил орчин үеийн шаардлагаас хоцорч байна. Үүнээс шалтгаалж, прокурорын байгууллагаас зохиосон ажил тэр болгон бодит үр дүнд хүрэхгүй байгаа нь манай ажлын үндсэн дутагдал юм. Юуны өмнө прокурорын байгууллагын зохион байгуулалт, төлөвлөлтийг оновчтой, дотоодын хяналт шалгалтыг хүчтэй болгож, ...дээд шатны прокуророос харьяа байгууллагуудаа удирдах удирдлагыг тодорхой болгох, прокурорын коллегий, зөвлөлийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэхээс уг ажлыг эхлэх хэрэгтэй гэж үзэж байна”⁵ хэмээн дурдаж, энэ чиглэлээрээ удирдлага зохион байгуулалтын үр дүнтэй, онцлог арга хэмжээг авч хэрэгжүүлж байсан нь түүхэн баримт бичиг болж үлдсэн байна. Тухайлбал, 1988 онд Прокурорын байгууллагын төв, орон нутгийн удирдах ажилтны зөвлөгөөнд тавьсан илтгэлдээ, прокуроруудыг хяналтын ажил болон эрх зүйгээр төрөлжүүлэн мэргэшүүлэх буюу тодорхой асуудал хариуцах зарчмаар ажиллуулах чиглэлийг өгсөн байна. Түүнчлэн зөрчлийн үр дагаварт тохируулж, мэдэгдэл, тоот, шаардлага бичихийг урьтал болгохгүйгээр тухайн байгууллагын хамт олноор нь хэлэлцүүлж, зөрчлийг засуулж арилгах, бүх хяналтын ажилд шалгалтаас гадна судалгааны ажил хийх нь хууль хэрхэн хэрэгжиж байгаад зөв дүгнэлт хийж,

² Монгол Улсын гавьяат хуульч О.Лхамсүрэн: Улсын ерөнхий прокурор байсан С.Бүдрагчаа прокурорыг Завхан аймгийн прокурор байхдаа аймгийн боловсролын хэлтсийн байцаагчаас прокурорын газарт байцаагчаар авч, прокурор болох замын нээсэн. Прокурорын байгууллагын түүхэн товчоон. УБ. 2020. 151 дэх тал

³ Улсын ерөнхий прокурорын газрын цахим хуудас. www.prosecutor.mn

⁴ Прокурорын байгууллагын түүхэн товчоон. УБ. 2020. 175 дахь тал

⁵ С.Бүдрагчаа. Улс, хөдөлмөрийн сахилга бэхжүүлэх талаарх хууль тогтоомжийн биелэлтэд тавих прокурорын хяналтын байдал, цаашдын зорилтын тухай. Илтгэл. БНМАУ-ын Ардын Их Хурлын чуулган. Үнэн сонин. УБ. 1987.12.13. №298. (16888)

зөрчил дутагдлыг арилгах арга замыг оновчтой тодорхойлох, ажлаа зөв зохион байгуулахад ач холбогдолтой арга хэмжээ болохыг зориуд цохон тэмдэглэж байжээ.

Мөн шинэ сэтгэлгээ, шинэлэг арга барилыг үйл ажиллагаандаа тууштай нэвтрүүлэх, шинийг эрэлхийлэх, эрх зүйн боловсрол, мэдлэгийн түвшинг дээшлүүлэх, ажил дүгнэх шалгуурыг зөв тогтоох зэрэг асуудлыг хөндөн шийдвэрлэж байжээ.

С.Бүдрагчаа прокурор ажлын хариуцлага, сахилга батыг дээшлүүлэх асуудалд ихээхэн анхаарч, прокурорын шалгалтаар орон нутгийн төр, захиргааны байгууллагад илэрсэн зөрчлийг арилгах талаар тодорхой ажил зохиох, прокурорын байгууллагын ажлыг дэмжих талаар захидал илгээдэг байсан нь тухайн үедээ шинэ содон зүйл байсан юм.

Хоёрдугаарт. Хяналтын ажлын зарим үзүүлэлт, үр нөлөө.

Улсын прокурорын нэгдүгээр орлогчоор хоёр дахь удаагаа ажиллаж эхэлсэн үе буюу 1979 онд түүний хариуцсан ерөнхий хяналтын чиглэлээр 2551 байгууллагад хууль тогтоомжийн биелэлтийг шалгаж, 237.2 мянган эрхийн акт хянан, 22.3 сая төгрөгийн хохирлыг улсад нөхөн төлүүлсэн⁶ бол 1981 онд 2476 байгууллагад хууль тогтоомжийн биелэлтийг шалгаж, 257.9 мянган эрхийн акт хянаж, 53.9 сая төгрөгийг нөхөн төлүүлсэн⁷ зэргээр тоо, чанарын хувьд онцгой ахиц гарсан нь түүний удирдан зохион байгуулах авьяас, мэдлэг, ур чадвартай шууд холбоотой.

Гуравдугаарт. Прокурорын байгууллагын дээд шагналыг бий болгосон.

Прокурорын байгууллагад олон жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажилласан прокурор, мөрдөн байцаагч, ажилтан, түүнчлэн гэмт хэрэг, эрх зүйн зөрчилтэй тэмцэхэд өндөр амжилт гаргасан бусад байгууллагын ажилтныг шагнаан урамшуулж байх зорилгоор Улсын прокурор С.Бүдрагчаа “Прокурорын хүндэт ажилтан” тэмдэг бий болгох саналыг тодорхойлолт, тэмдгийн загварын хамт боловсруулж, Ардын Их Хурлын Тэргүүлэгчдэд хүргүүлсэн байдаг. Ийнхүү Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1988 оны 11 дүгээр зарлигаар “Прокурорын хүндэт ажилтан” тэмдгийг бий болгосон. Уг тэмдгээр шагнаж байх эрхийг БНМАУ-ын прокурорт олгожээ.⁸

Дөрөвдүгээрт. Прокурорын байгууллагад шинжлэх ухаанч, бүтээлч хандлагыг төлөвшүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн.

С.Бүдрагчаа прокурор, Гэмт хэргийн шалтгаан нөхцөл судлах хүрээлэнгийн захирлаар хавсран ажиллаж байхдаа, гэмт хэрэгтэй тэмцэх төрийн бодлогыг хэрэгжүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулахад туслах зорилготой улсын хэмжээнд үйлдэгдэж байгаа гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судлах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулах чиг үүрэг бүхий эрдэм шинжилгээний байгууллага болж өргөжин хөгжихөд бодитой хувь нэмэр оруулсан.

Түүнчлэн 1984 онд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулах, хэрэгжүүлэх үүрэг бүхий 5 орон тоотой “Тоо бүртгэл, мэдээлэл судалгааны тасаг”, Улсын прокурорын газрын дэргэд 14 орон тоотой “Эрдэм шинжилгээ, арга зүйн зөвлөл”-ийг тус тус байгуулж ажиллуулсан.

С.Бүдрагчаа прокурор хууль тогтоомжийг олон нийтэд түгээх, хуулийн зөрчлийг жишээ баримтаар дурдаж, холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, хурал, зөвлөгөөнд илтгэл хэлэлцүүлэх, санал дүгнэлт гаргах, хэвлэл мэдээллийн байгууллагатай нягт хамтран

⁶ Прокурорын байгууллагын түүхэн товчоон. УБ. 2020. 174 дэх тал

⁷ Мөн тэнд. 183 дахь тал

⁸ Мөн тэнд 201-202 дахь тал

ажиллах зэргээр хууль тогтоомжийг сурталчлах, тайлбарлан таниулах, иргэдийг соён гэгээрүүлэхэд манлайлагч нэгэн байсан.

Тухайлбал, Хуулийг сахин биелүүлэх нь иргэн бүрийн үүрэг сэдвээр “Хөдөлмөр” сонины уншигчдын асуултад шууд хариулах⁹, Үндэсний телевизээр “Хариуцлага хүлээлгэхэд оршиж буй дутагдал”-ын талаар ярилцлага¹⁰ өгөх, “Прокурорын байгууллагын ажлыг улам сайжруулъя”¹¹ өгүүлэл, “Аж ахуйч биш явдлын хор уршиг”¹² өгүүлэл, “Ажилд авах ба халах журам”¹³ өгүүлэл, “Социалист хууль ёсыг бэхжүүлэхийн төлөө”¹⁴ өгүүлэл, “Шинэ нөхцөлд зохицуулан ажлын арга барилаа сайжруулъя” өгүүлэл¹⁵, “БНМАУ-ын прокурорын байгууллагын зохион байгуулалт, ажлын арга”¹⁶ өгүүлэл, “Согтууралтай хийх тэмцлийг идэвхжүүлэх нь нийслэл Улаанбаатар хотод гэмт явдлыг бууруулах үндсэн нөхцөл мөн”¹⁷ илтгэл, “Төв аймагт үйлдэгдэж буй гэмт хэрэг, эрх зүйн зөрчилтэй тэмцэх ажлын чанар, үр нөлөөг дээшлүүлсе” илтгэл¹⁸ зэрэг олныг дурдаж болно.

Улсын прокурорын туслах прокуророор 1958-1961 онуудад ажиллаж байхдаа Улсын прокурорын нэгдүгээр орлогч Л.Цэндтэй хамтран “Прокурорын хяналт” номыг¹⁹ бичиж, 1962 онд 3000 хувь хэвлүүлжээ. Энэхүү ном 12 бүлэгтэй бөгөөд прокурорын хяналтад багтах асуудлууд, прокурорын хяналтын хөгжил, хууль ёс ба прокурорын хяналт, удирдлага зохион байгуулалтын үндсэн зарчим, урьдчилсан мөрдөн байцаах ажиллагаанд тавих прокурорын хяналт, прокурор эрүүгийн хэргийн талаар тавих шүүхийн хяналт, хорих газруудын ажиллагаанд тавих прокурорын хяналт, гадаад орнуудын прокурорын байгууллагууд зэрэг сэдвийг хамруулсан бүтээл болсон байдаг.

Энэхүү номыг улсын прокурор, шүүх, нийгмийг аюулаас хамгаалах байгууллагын ажилтнууд, хууль цаазын дээд, дунд сургууль, курст суралцагчид, хуулийн байгууллагуудтай холбогдох ажил эрхлэгчид, хуулийн ажил сонирхогчдод зориулагдсан гэж номын зохиогч тэмдэглэсэн байдаг. Дээрх бүтээл нь прокурорын байгууллагын талаарх баялаг мэдээлэлтэй, прокурорын хяналтын түүхэн уламжлалыг тодорхой гаргаж толилуулсан, эрэлт хэрэгцээтэй анхны сурах бичиг бөгөөд одоо цагийн эрдэмтэн, судлаачдад үнэтэй эх сурвалж болсоор байна.

Тавдугаарт. Прокурорын байгууллагын хүний нөөцийг чадавхжуулах, прокурор, ажилтнуудыг сургах, урамшуулан дэмжихэд онцгой анхаарсан.

Аливаа байгууллагын үйл ажиллагаа хүний нөөц бүрдүүлэлт, боловсрол, мэдлэг, мэргэшил зэргээс ихээхэн хамаардаг билээ.

Улсын прокурор С.Бүдрагчаа 1986 онд ЗХУ-д айлчлахдаа, тус улсын Прокурорын газартай хамтын ажиллагааны гэрээнд гарын үсэг зурснаар урьд нь жил бүр 10 албан хаагч сургалтад хамрагдаж байсныг нэмэгдүүлж, 1987 оноос эхлэн ЗХУ-ын нийслэл Москва болон

⁹ Хөдөлмөр сонин. УБ. 1987.03.14. №30. (10129)

¹⁰ Монголын үндэсний телевиз. УБ. 1985.12.07

¹¹ Төр эрх сэтгүүл. УБ. 1960.№05

¹² Эдийн засаг эрхийн асуудал. сэтгүүл.УБ.1961.№02

¹³ Мөн тэнд.1961.№06

¹⁴ Ардын төр. УБ.1969 .№06

¹⁵ Мөн тэнд. №03

¹⁶ Мөн тэнд. №06

¹⁷ “Согтуурлын нийгмийн хор уршгийг даван туулах арга зам” эрдэм шинжилгээний практикийн бага хурал. 1987.07.27

¹⁸ Онол-практикийн хурал. Зуунмод. 1983

¹⁹ Л.Цэнд.С.Бүдрагчаа.Прокурорын хяналт. УБ. 1962. МУИС .ХЗС. данс.935690,9356.91

Ленинград, Киев, Харьков зэрэг томоохон хотуудад 50 гаруй прокурор, мөрдөн байцаагч нарыг 14 хоногоос 3 сар хүртэлх хугацаагаар илгээж, мэргэжил дээшлүүлж суралцуулсан байна.²⁰

Тэрбээр шинэ залуу чадварлаг хуульчдаар прокурорын байгууллагын хүний нөөцийг бүрдүүлэхэд ихэд анхаарч байв. Тухайлбал, 1980-аад онд прокурорын байгууллагад Н.Жанцан (Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Үндсэн хуулийн цэцийн дарга, хууль зүйн ухааны доктор, профессор), Ц.Нямдорж (Монгол Улсын Гавьяат хуульч, Улсын Их Хурлын дарга, Хууль зүй, дотоод хэргийн сайд), Д.Лүндээжанцан (Монгол Улсын Гавьяат хуульч, Улсын Их Хурлын дарга, хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор), Л.Цог (Монгол Улсын Гавьяат хуульч, Улсын Их Хурлын дэд дарга), Ц.Оюунбаатар (Монгол Улсын Гавьяат хуульч), Б.Дэлгэрмаа (Улс төрийн зүтгэлтэн, доктор) зэрэг олон прокурорууд нэр төртэй ажиллаж, тэдгээрийг сургаж хүмүүжүүлэх, өсөж өндийхөд нь С.Бүдрагчаа прокурорын оруулсан хувь нэмэр их билээ. Монгол Улсын Төрийн шагналт, Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, академич, хууль зүйн шинжлэх ухааны доктор, МУИС-ийн эмерит профессор С.Нарангэрэл дурсан ярихдаа: “МУИС-д 10 жил багшилж байв, 1985 онд Улсын ерөнхий прокурор С.Бүдрагчаа гэнэт дуудаж уулзсан. Тэрбээр “Хотын намын хорооноос хууль сайн мэддэг залуу хүнийг Улаанбаатар хотын прокурорын даргаар томил гэсэн чиглэл өгсөн. Тэр хүнд нь С.Нарангэрэл гэх хуулийн сургуулийн залуухан багш буюу чи таарч тэнцжээ. Иймд ажлаа хүлээж ав” гээд Улаанбаатар хотын ерөнхий прокурорын орлогчоор томилсон.”²¹ гэсэн байдаг.

Зургаадугаарт. Хүний эрхийг хангах, шударга ёсыг тогтооход оруулсан түүний хувь нэмэр үлэмж их юм.

С.Бүдрагчаа прокурор шударга ёс, хүний эрх, эрх чөлөөг дээдэлдэг, зөрчигдсөн эрхийг сэргээхэд хүчин чармайлт тавьдаг, аливаа хэлмэгдэл гаргахаас урьдчилан сэргийлдэг, буурь суурьтай хуульч байсан.

Тэрбээр Ардын Их Хурлын чуулган дээр тавьсан илтгэлдээ, ...зарим иргэд гарсан гэмт хэргийн тухай мэдээлэхгүй, нуун дарагдуулах, ажлын зарчимч шаардлага, хууль ёсоор авсан арга хэмжээнд дургүйцж, гэм буруугаа хаацайлсан буюу бусдыг мушгин гуйвуулж, гүтгэсэн зүйл бичиж, ихээхэн чирэгдэл учруулдагтай зүй ёсны тэмцэл хийнэ²² гэж дурдсан нь практик дээр батлагдсан байдаг.

Бодит жишээнээс үзэхэд, Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Ардын жүжигчин Г.Жигжидсүрэн ...“Хүний амь киног социалист нийгмийн үзэл санаанд тохирохгүй, хар сэдэвтэй, муу муухай юм харуулах гэлээ гэсэн. Харин тэр киноны амийг аварсан хүн нь генерал С.Бүдрагчаа гуай юм.”²³ гэж, 1978 онд “Гавьяа” найруулал бичиж мөрдөн шалгагдсан Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн Г.Жамьян ...“Толгойлогч” намайг МАХН-аас хөөж, ажлаас халан прокурорын мэдэлд шилжүүлэхэд Улсын прокурор С.Бүдрагчаа намайг аварсан. Г.Жамьянгийн асуудалд эрүүгийн хэрэг үүсгэх нөхцөл байдал алга”²⁴ гэсэн гэнэ лээ.” гэж ярилцлага өгсөн байдаг.

²⁰ Прокурорын байгууллагын түүхэн товчоон. УБ. 2020. 198-200 дахь тал

²¹ Э.Хүрэлбаатар, Монголын хуульчдын ноён оргилуудын нэг академич С.Нарангэрэлийнх. www.ergelt.mn. 2023.01.28

²² С.Бүдрагчаа. Улс, хөдөлмөрийн сахилга бэхжүүлэх талаарх хууль тогтоомжийн биелэлтэд тавих прокурорын хяналтын байдал, цаашдын зорилтын тухай. илтгэл БНМАУ-ын Ардын Их Хурлын чуулган. Үнэн сонин. УБ. 1987.12.13. №298. (16888)

²³ Д.Цэрэннадмид. Монгол киноны дэлгээтэй судар буюу Гомбожавын Жигжидсүрэн. Зууны мэдээ сонин. УБ.2018.10.15

²⁴ Хар мөр дагуулсан “Гавьяа”. www.history.mn

Долоодугаарт. Өргөн мэдлэгтэй, өндөр ур чадвартай, прокурорын байгууллагын ноён нуруутай удирдагч юм.

С.Бүдрагчаа прокурорын талаар ахмад хуульчдын дурсамжаас сөхвөл, 1960-1969 онуудад Улсын прокуророор ажиллаж байсан, хошууч генерал Д.Ёндондүйчир “Улсын прокурорын газарт ажиллаж байсан он жилүүдэд миний нэгдүгээр орлогчоор С.Бүдрагчаа ...зэрэг санаачилга, баялаг туршлага, идэвх зүтгэлтэй прокурорууд ажиллаж байлаа”²⁵, Л.Адъяа “Прокурорууд маань Улсын прокурорын Бүдрагчаа нарын тулх сайтай удирдагчаас их зүйл сурч, хамт ажиллаж байсан”²⁶, Б.Намхай “Улсын прокурор С.Бүдрагчаа зэрэг манай улсын өмнөө барьдаг хуульчид, төрийн зүтгэлтнүүд төрж гарсан нь залуу прокуроруудад энэ албандаа хүч чадлаа дайчлан ажиллах үлгэр дуурайл болсоор байна.”²⁷, Г.Тогоонтөмөр “...Миний бие прокурорын байгууллагад 40 гаруй жил ажиллаж, мөрдөн байцаагчаар ажиллахдаа үе үеийн шилдэг прокурор, мөрдөн байцаагч, прокурорын байгууллагын удирдлагуудтай ажиллаж байснаа дурсан санаж бахархдаг. БНМАУ-ын прокурор С.Бүдрагчаа зэрэг хүмүүстэй хамт ажиллаж байснаа дурсан санахад, сэтгэлийн үзүүрт баярын нулимс дусалдаг болохыг өтгөс болсон өдий үедээ бие сэтгэлээр мэдэрч байдаг билээ”²⁸ зэргээр дурсамж, дурдатгалдаа эрхэм прокурорын талаар бичиж үлдээжээ.

Өвөрхангай аймгийн прокурорын газрын хамт олон С.Бүдрагчаа прокурорыг Нийгмийг аюулаас хамгаалах яамны нэгдүгээр орлогч сайд, Улсын цагдан сэргийлэх ерөнхий газрын даргаар 1988 онд шилжин томилогдох үед нь “Та бид бүхэнтэй 9 жил гаруй хугацаанд ажиллахдаа, нэгдмэл удирдлагаар прокурорын байгууллагын ил тод ажиллагаа, боловсон хүчний сахилга хариуцлага, материаллаг бааз, аж ахуй, орон нутгийн прокурорын байгууллагын бэхжилт, нэр хүндийн талаар шинэчлэлт, өөрчлөлт хийж, олон чухал асуудлыг хөндөж шийдвэрлүүлсэн билээ”²⁹ хэмээн талархлаа илэрхийлсэн байдаг.

1992 оны шинэ Үндсэн хуульд³⁰ “Прокурорын байгууллагын тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно” гэсэн нь Прокурорын байгууллагын тухай хуулийг шинэчлэн гаргах хэрэгцээ, шаардлагыг бий болгосон.

Хуулийн төсөл боловсруулах ажлыг Улсын ерөнхий прокурор Г.Бахдал өөрөө удирдан зохион байгуулж, уг хуулийн төсөлд санал авахаар Улсын прокуророор ажиллаж байсан ...С.Бүдрагчаа нарыг урьж, хуулийн төслийг танилцуулж, санал шүүмжийг нь тусган боловсруулсан³¹ болохыг тэмдэглэн хэлэх нь зүйтэй.

Дүгнэлт

Монгол Улсын Прокурорын байгууллагын хөгжилд БНМАУ-ын прокурор С.Бүдрагчаагийн оруулсан түүхэн гавьяа зүтгэлийг тоймлон үзвэл:

Прокурорын байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, хяналтын ажлын арга барил, чанар, үр нөлөөг сайжруулах, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, аливаа асуудалд шинжлэх ухаанчаар хандах хандлагыг төлөвшүүлэхэд онцгой үүрэг гүйцэтгэсний зэрэгцээ гадаад улсад жилд 50 гаруй прокурорыг мэргэжил дээшлүүлж,

²⁵ Прокурорын байгууллагын түүхэн товчоон. УБ. 2020. 115 дахь тал

²⁶ Алдраар жигүүрлэсэн ахмад үеийнхэн. УБ. 2010.195 дахь тал

²⁷ Мөн тэнд.102 дахь тал

²⁸ Мөн тэнд.133-134 дэх тал

²⁹ Өвөрхангай аймгийн прокурорын газрын 1988 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн №1/219 дугаартай албан бичиг

³⁰ Монгол Улсын Үндсэн хууль. Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. 1992. №01

³¹ Мөн тэнд. 2020.222 дахь тал

сургалтад хамруулж эхэлсэн зэрэг олон талт үйл ажиллагаа явуулж байсныг дурдахад таатай байна.

С.Бүдрагчаа прокурор нь ажил, амьдралын баялаг туршлагатай, чадварлаг удирдагч, хууль ёсыг чанд сахиулахад бие сэтгэлээ бүрэн зориулсан, хөдөлмөрч, хүний эрхийг хамгаалагч, хойч үеийнхний бахархан дуурайх оюунлаг хүмүүн, Монгол төрийн нэрт зүтгэлтэн байсан гэдгийг тодотгож байна.

Ашигласан материал

1. Улсын ерөнхий прокурорын газар. Прокурорын байгууллагын түүхэн товчоон. УБ. 2020
2. Улсын ерөнхий прокурорын газрын цахим хуудас. www.prosecutor.mn
3. С.Бүдрагчаа. Улс, хөдөлмөрийн сахилга бэхжүүлэх талаарх хууль тогтоомжийн биелэлтэд тавих прокурорын хяналтын байдал, цаашдын зорилтын тухай. Илтгэл. БНМАУ-ын Ардын Их Хурлын чуулган. Үнэн сонин. УБ. 1987.12.13. №298. (16888)
4. Хөдөлмөр сонин. УБ. 1987.03.14. №30. (10129)
5. Монголын үндэсний телевиз. УБ. 1985.12.07
6. Төр эрх сэтгүүл. УБ. 1960.№05
7. Эдийн засаг эрхийн асуудал. сэтгүүл.УБ.1961.№02
8. Ардын төр. УБ.1969 .№06
9. “Согтуурлын нийгмийн хор уршгийг даван туулах арга зам” эрдэм шинжилгээний практикийн бага хурлын материал. 1987.07.27
10. Л.Цэнд.С.Бүдрагчаа.Прокурорын хяналт. УБ. 1962. МУИС .ХЗС. данс.935690,9356.91
11. Э.Хүрэлбаатар, Монголын хуульчдын ноён оргилуудын нэг академич С.Нарангэрэлийнх. www.ergelt.mn. 2023.01.28
12. Д.Цэрэннадмид. Монгол киноны дэлгээтэй судар буюу Гомбожавын Жигжидсүрэн. Зууны мэдээ сонин.УБ.2018.10.15
13. Хар мөр дагуулсан “Гавьяа” нийтлэл. www.history.mn
14. Өвөрхангай аймгийн прокурорын газрын 1988 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн №1/219 дугаартай албан бичиг